



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 185

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 18 нэрийн нийт 527,840,732.02 (таван зуун хорин долоон сая найман зуун дөчин мянга долоон зуун гучин хоёр төгрөг хоёр мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ц.Минжинхүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, худалдах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



132001392

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн
81 дугаар тогтоолын хавсралт

**"ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	
1	Плазм оглогч/0010010013246/-ТДЦ	2012.12.31	ш	1	1,162,408.48	
2	Гагнуурын аппарат ВДУ 504/0010010010132/-Зуух	1997.01.01	ш	1	2,038,020.31	
3	Нүүрс шидэгч К-1/0010010010833/-Зуух	1961.01.01	ком	1	139,056,634.76	
4	Шаталтын тавцан, К-1/0010010010834/-Зуух	1961.01.01	ком	1	342,362,628.10	
5	Муфельный печь/0010010010191/-ТХЦ	2002.01.01	ш	1	3,974,322.50	
6	Ус нэрэгч аппарат/0010010010037/-ТХЦ	2001.01.01	ш	1	1,528,585.60	
7	Сийрэжжилтийн насос/0010010010039/-ТХЦ	1970.01.01	ш	1	3,905,286.41	
8	Ус цэвэрлэгээний хэмжүүрүүд UFM-001/0010010010185/-ТХЦ	1999.01.01	ш	1	12,915,321.58	
9	Компьютер PIV 512 mb/0010010010615/	2001.12.31	ш	1	500,000.00	
10	Компьютер Acer/0010010013240/	2012.12.31	ш	1	600,000.00	
11	Принтер Samsung/0010010013218/	2012.09.30	ш	1	300,000.00	
12	Компьютер Dell/0010010013140/	2011.11.30	ш	1	800,000.00	
13	Дотоод холбооны АТС/0010010010928/-КХДТ 500	2007.07.31	ком	1	7,479,009.03	
14	Дотоод холбооны АТС/0010010010925/-КХДТ 50175	2007.07.31	ком	1	1,699,774.78	
15	Дотоод холбооны АТС/0010010010924/-КХДТ 50170	2007.07.31	ком	1	1,586,456.46	
16	Дотоод холбооны АТС/0010010010931/-КХ-4	2007.07.31	ком	1	2,266,366.37	
17	Дотоод холбооны АТС/0010010010929/-КХДТ 520 станц	2007.07.31	ком	1	5,212,644.36	
18	Дотоод холбооны АТС/0010010010930/-КХТД 193	2007.07.31	ком	1	453,273.28	
					527,840,732.02	
					(таван зуун хорин долоон сая найман зуун дөчин мянга долоон зуун гучин хоёр төгрөг хоёр мөнгө)	

Нийт дүн